



**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3	Менежментийн захидал.....	9
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16
6	Төлбөрийн акт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН
ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН
КОМИССЫН ДАРГА Я.САНЖМЯТАВ
ТАНАА

2019.04.25 № 853
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2018 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон УСНББОУС, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.БҮРЭНБАТ

Аудитын тайлан

2.1. Оршил

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дарга Я.Санжмятав Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, улс төр, нам эвслийн хэлмэгдэгчдийн нөхөх олговорт анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс 4 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Болор-Эрдэнэ хариуцаж хэрэгжүүлэв.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дарга 2018 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2019 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 99 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”, түүнд тусгасан заавар аргачлалын дагуу горим сорилыг үе шатны чанарын хяналтыг хийлгэн, нотлох зүйлсийг баримтжуулсан.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад, дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс нь төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн, нам, төрийн бодлого, шийдвэрт шүүмжлэлтэй хандсан гэх шалтгаанаар хилсээр шийтгүүлсэн, нам, захиргааны байгууллагаас хилсээр арга хэмжээ авагдсан иргэдийн хэргийг шалгаж, шийдвэрлүүлэх, хэлмэгдсэн иргэнд хууль тогтоомжийн дагуу тэтгэмж, тусламж, нөхөх олговор олгуулах, хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээн сурталчлахад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг татан оролцуулах, улс төрийн хэлмэгдүүлэлтийн уршигт үр дагаврыг арилгах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 6.3-т цагаатгуулах тухай гомдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл гаргаж болох, 13.2.1, 13.2.2-т хэлмэгдэгчдэд шийтгэлийн төрлөөс шалтгаалан нөхөх олговрын хэмжээг 40.0 сая, 80.0 сая төгрөгөөр олгож байхаар хуульчилсан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Тус байгууллага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамж ашигладаг байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын бэлтгэсэн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад, дотоод орчин, дотоод хяналтыг судалж, түүнтэй холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Тус байгууллагын санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлж, материаллаг эрсдэлийг тодорхойлон суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгох нь зүйтэй гэж үзсэн.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2018 оны нийт зардал 657.0 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 6.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисст төсвийн шууд болон төсвийн төвлөрүүлэн захирагч харьяа байгууллага хамардаггүй тул аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Хүснэгт 1 (Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал, сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн
1	Зөвлөмж өгсөн	2	0.8
2	Төлбөрийн акт тогтоосон	1	5.5
Дүн		3	6.3

Эх сурвалж: Аудитын горим, сорилын ажлын баримт

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1: Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

Комиссын нарийн бичгийн даргын 2018 оны А/15, А/28 дугаар тушаалаар хагас, бүтэн жилийн үр дүнгийн гэрээний урамшуулалд 13.9 сая төгрөг, Комиссын даргын 2018 оны 04 дүгээр захирамжаар 7 гэрээтэд 36.3 сая төгрөг нийт 50.2 сая төгрөгийн цалин хөлснөөс 5.5 сая төгрөгийн НДШ-ийг суутгаагагүй олгосон нь Төсвийн тухай хуулийн 14.2.3, Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдэл: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан 2019 оны төсөв 5.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан тул холбогдох хуулийн хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалт тэдгээрт тавигдах хяналтыг хамруулах нь зүйтэй гэж үзлээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисст 2018 онд чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь зориулж 647.6 сая төгрөгийн төсөв батлагдснаас 595.3 сая төгрөг буюу 92.0 хувийг нь зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу 2018 онд нийт 100 мэдээлэл байршуулахаас санхүүжилт болон зарцуулалтын 85 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод, иж бүрэн байршуулж, 15 мэдээллийг хугацаа хоцроон хэрэгжилт 85.0 хувьтай байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг аудитын явцад нягтлан шалгахад 97.0 хувьтай байгаа бөгөөд хэрэгжилт хангалтгүй зөвлөмжийн талаар В30103 батлагдсан маягтад тодорхой дурдаж аудитын явцад алдаа зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллав.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2018 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн талаар Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой

3.1.1 Илрүүлэлт:

Тээвэр шатахууны 0.8 сая төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолуудтай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийг зарцуулахдаа холбогдох эрх зүйн актыг зөрчсөн байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, холбогдох дүрэм журамд нийцүүлэн ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага В20101, В501 маягтад заагдсан асуудлын бүртгэлтэй танилцан, хүлээн зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулсан.

3.2 Удирдлагын болон дотоод хяналт

3.2.1 Илрүүлэлт:

Хилсээр шийтгүүлсэн, нам, захиргааны байгууллагаас хилсээр арга хэмжээ авагдсан иргэдийн хэргийг шалгаж, шийдвэрлүүлэх, хэлмэгдсэн иргэнд хууль тогтоомжийн дагуу тэтгэмж, тусламж, нөхөх олговор олгож буй шүүхийн шийдвэрийг салбар зөвлөл буюу орон нутаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дансаар дамжуулан олгож байгаа нь хэлмэгдэгчдийн ар гэр, ач

ээ, үр хүүхдэд нь төрийн үйлчилгээг олон шат дамжлагаар их цаг хугацаа зарцуулж хүргэж, ахин анхан шатны баримтаас хөөн шалгах, тулган баталгаажуулахад иргэдэд хүндрэл учруулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Төсвийг зарцуулахдаа холбогдох эрх зүйн актыг зөрчих, иргэдэд төрийн үйлчилгээ чирэгдэлгүй шуурхай хүрэхгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нийцүүлэн байгууллагын онцлогт тохируулан журам батлуулах, шүүхийн нөхөх олговрын шийдвэрийг хэлмэгдэгчийн ар гэрийнхний холбогдох дансанд шууд шилжүүлэх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллага В20101, В501 маягтад заагдсан асуудлын бүртгэлтэй танилцан, хүлээн зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулсан хэдий ч нэмэлт зөвлөмж авах хүсэлт тавьсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35,422.2	12,314.4
33	АВЛАГА	285.0	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	285.0	-
34	УРЬДЧИЛГАА	14,479.3	-
3471	Урьдчилгаа тооцоо	14,479.3	-
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	5,800.0	-
34714	Томилолтын урьдчилгаа	8,679.3	-
35	БАРАА МАТЕРИАЛ	20,657.9	12,314.4
354	Хангамжийн материал	20,657.9	12,314.4
35410	Бичиг хэргийн материал	5,579.8	2,323.7
35470	Бусад хангамжийн материал	15,078.1	9,990.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	37,509.5	51,290.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	37,509.5	51,290.6
392	Биет хөрөнгө	33,384.5	45,738.5
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,874.9	50,282.5
39206	Хуримтлагдсан элэгдэл	-41,110.3	-25,868.1
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,857.0	25,184.4
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,701.7	-12,325.1
39217	Ном	8,464.7	8,464.7
393	Биет бус хөрөнгө	4,125.0	5,552.1
39301	Програм хангамж	14,155.0	20,655.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-10,030.0	-15,102.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	72,931.7	63,605.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,094.3	24.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,094.3	24.1
413	Өглөг	3,094.3	24.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	69,837.4	63,580.9
51	Засгийн газрын хувь оролцоо	69,837.4	63,580.9
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	50,239.4	50,239.4
51101	Өмч: - төрийн	50,239.4	50,239.4
512	Хуримтлагдсан үр дүн	18,766.2	12,509.7
51210	Өмнөх үеийн үр дүн	18,766.2	21,860.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	831.8	831.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	72,931.7	63,605.0

2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	571,687.5	647,587.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,900.0	-
122	Тусламжийн орлого	7,900.0	-
122001	Хандив тусламж /дотоод/	7,900.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	563,787.5	647,587.5
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	563,787.5	647,587.5
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	563,787.5	647,587.5
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	529,043.6	656,938.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	287,455.1	452,887.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	287,455.1	452,887.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	140,878.5	147,595.7
210101	Үндсэн цалин	108,757.1	146,376.5
210102	Нэмэгдэл	25,005.9	1,219.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,115.5	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,176.7	18,546.8
210201	Тэтгэврийн даатгал	17,176.7	15,179.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,580.0	31,450.1
210304	Байрны түрээс	27,580.0	31,450.1
2104	Хангамж, бараа материалын зардал	23,741.7	36,129.0
210401	Бичиг хэрэг	4,910.6	7,668.7
210402	Тээвэр, шатахуун	8,061.0	16,511.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,114.4	3,253.7
210404	Ном, хэвлэл	5,374.8	5,766.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,280.9	2,928.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,304.0	18,017.0
210604	Урсгал засвар	8,304.0	18,017.0
2107	Томилолт, зочны зардал	14,312.6	49,860.9
210702	Дотоод албан томилолт	14,312.6	34,022.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,760.8	115,022.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,447.3	112,377.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	313.5	2,645.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,700.9	36,265.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,086.0	5,794.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,218.4	17,800.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,396.5	12,671.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	241,588.5	204,050.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	227,501.2	151,766.3
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	17,691.2	17,630.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	206,510.0	134,136.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,300.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,087.3	52,284.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,087.3	52,284.3
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	42,643.9	-9,350.8
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	42,643.9	-9,350.8

3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	571,687.5	647,587.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,900.0	-
122	Тусламжийн орлого	7,900.0	-
122001	Хандив тусламж /дотоод/	7,900.0	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	563,787.5	647,587.5
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	563,787.5	647,587.5
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	563,787.5	647,587.5
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	561,130.2	627,754.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	561,130.2	627,754.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	296,905.9	421,006.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	140,878.5	143,314.1
210101	Үндсэн цалин	108,757.1	104,040.7
210102	Нэмэгдэл	25,005.9	32,157.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,115.4	7,115.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,591.1	17,419.0
210201	Тэтгэврийн даатгал	15,591.1	11,612.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,580.0	31,450.1
210304	Байрны түрээс	27,580.0	31,450.1
2104	Хангамж, бараа материалын зардал	25,080.1	28,904.5
210401	Бичиг хэрэг	4,111.8	4,412.6
210402	Тээвэр, шатахуун	6,917.1	16,511.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,906.0	3,253.6
210404	Ном, хэвлэл	7,900.0	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,245.3	4,726.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,304.0	18,017.0
210604	Урсгал засвар	8,304.0	18,017.0
2107	Томилолт, зочны зардал	24,135.8	41,181.5
210702	Дотоод албан томилолт	24,135.8	34,022.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,339.5	117,426.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,850.0	114,781.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,489.5	2,645.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,996.9	23,294.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,231.5	5,494.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,765.4	17,800.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	264,224.3	206,747.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,137.0	154,463.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	40,327.0	20,327.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	206,510.0	134,136.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,300.0	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,087.3	52,284.3
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,087.3	52,284.3
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	10,557.2	19,833.5
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	10,557.2	19,833.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,557.2	19,833.5
2200	Дотоод эх үүсвэрээр	10,557.2	19,833.5
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,557.2	19,833.5
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-10,557.2	-19,833.5
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,239.4	831.8	-72,208.4	-21,137.2
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,239.4	831.8	-72,208.4	-21,137.2
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	29,098.5	29,098.5
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,239.4	831.8	18,766.2	69,837.4
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	3,094.3	3,094.3
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	50,239.4	831.8	21,860.5	72,931.7
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	-9,350.8	-9,350.8
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	50,239.4	831.8	12,509.7	63,580.9

5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	647,587.5	595,303.2	52,284.3	91.9
УРСГАЛ ЗАРДАЛ	647,587.5	595,303.2	52,284.3	91.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	452,460.5	440,840.2	11,620.3	97.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,314.1	143,314.1	-	100.0
Үндсэн цалин	104,040.7	104,040.7	-	100.0
Нэмэгдэл	32,157.9	32,157.9	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	7,115.5	7,115.5	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,419.0	17,419.0	-	100.0
Тэтгэврийн даатгал	11,612.6	11,612.6	-	100.0
Тэтгэмжийн даатгал	1,451.6	1,451.6	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	1,161.2	1,161.2	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	290.4	290.4	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	2,903.2	2,903.2	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,990.3	31,450.1	540.2	98.3
Байрны түрээс	31,990.3	31,450.1	540.2	98.3
Хангамж, бараа материалын зардал	34,877.5	34,128.7	748.8	97.9
Бичиг хэрэг	4,412.6	4,412.6	-	100.0
Тээвэр, шатахуун	16,917.1	16,511.8	405.3	97.6
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,592.5	3,253.7	338.8	90.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,955.3	9,950.7	4.6	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	18,316.0	18,017.0	299.0	98.4
Урсгал засвар	18,316.0	18,017.0	299.0	98.4
Томилолт, зочны зардал	44,353.9	41,181.6	3,172.3	92.8
Дотоод албан томилолт	44,353.9	34,022.7	10,331.2	76.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	137,112.7	130,256.0	6,856.7	95.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	121,637.7	114,781.0	6,856.7	94.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	15,475.0	15,475.0	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	25.1	25.1	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	7,277.0	7,273.8	3.2	99.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,800.0	17,800.0	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,127.0	154,463.0	40,664.0	79.2
Бусад урсгал шилжүүлэг	195,127.0	154,463.0	40,664.0	79.2
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,327.0	20,327.0	-	100.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	174,800.0	134,136.0	40,664.0	76.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	647,587.5	647,587.5	-	-
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	647,587.5	647,587.5	-	-
Улсын төсвөөс санхүүжих	647,587.5	647,587.5	-	-
Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл	-	-	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
АЖИЛЛАГСАДЫН ТОО	11	11		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	6	6		
Үйлчлэх ажилтан	4	4		
Гэрээт ажилтан	-	-		

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2019/5/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
1	Тээвэр шатахууны 0.8 сая төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	0.8	Зөвлөмж өгсөн	Комиссын Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	П.Нарандалай Т.Алтанцэцэг
2	Хилсээр шийтгүүлсэн, нам, захиргааны байгууллагаас хилсээр арга хэмжээ авагдсан иргэдийн хэргийг шалгаж, шийдвэрлүүлэх, хэлмэгдсэн иргэнд хууль тогтоомжийн дагуу тэтгэмж, тусламж, нөхөх олговор олгож буй шүүхийн шийдвэрийг салбар зөвлөл буюу орон нутаг, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дансаар дамжуулан олгож байгаа нь хэлмэгдэгчийн ар гэр, ач зээ, үр хүүхдэд төрийн үйлчилгээг олон шат дамжлагаар их цаг хугацаа зарцуулж хүргэж, ахин анхан шатны баримтаас хөөн шалгах, тулган баталгаажуулахад иргэдэд хүндрэл учруулж байна.	-	Зөвлөмж өгсөн	Комиссын Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	П.Нарандалай Т.Алтанцэцэг
3	Комиссын нарийн бичгийн даргын 2018 оны А/15, А/28 дугаар тушаалаар хагас, бүтэн жилийн үр дүнгийн гэрээний урамшуулалд 13.9 сая төгрөг, Комиссын даргын 2018 оны 04 дүгээр захирамжаар 7 гэрээтэд 36.3 сая төгрөг нийт 50.2 сая төгрөгийн цалин хөлснөөс 5.5 сая төгрөгийн НДШ-ийг суутгаагаагүй олгосон байна.	5.5	Төлбөрийн акт тогтоосон	Комиссын Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	П.Нарандалай Т.Алтанцэцэг
	Дүн	6.3			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2019 оны 04 дугаар сарын 19

№ 01/81

Улаанбаатар хот

С.БТ- 2019/5/СТА-ТЭВ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын даргын төсвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Комиссын нарийн бичгийн даргын 2018 оны А/15, А/28 дугаар тушаалаар хагас, бүтэн жилийн үр дүнгийн гэрээний урамшуулалд 13,896,676.0 төгрөг, Комиссын даргын 2018 оны 04 дүгээр захирамжаар байнгын шинжтэй 7 гэрээтэд 36,270,000.0 төгрөг нийт 50,166,676.0 төгрөгийн цалин хөлснөөс 5,518,334.0 төгрөгийн НДШ суутгалгүй илүү олгосон байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-д “...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Албан хаагчдад илүү олгосон 5,518,334.0 /таван сая таван зуун арван найман мянга гурван зуун гучин дөрвөн/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 100900000601 тоот дансанд 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын Нарийн бичгийн дарга Д.Ууганбаатар, нягтлан бодогч Т.Алтанцэцэг нарт хариуцуулав.

АКТЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР Д.БОЛОР-ЭРДЭНЭ

ЗӨВШӨӨРСӨН:

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН
БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Д.УУГАНБААТАР

НЯГТЛАН БОДОГЧ
Т.АЛТАНЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тасвасан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichig_Kherreg\Akt\2019\0419SAG1.Docx

070260





ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.